

Зуухны насосны машинчийн III зэргийн мэргэжлийн шалгалтын асуулт

1	Зуухны хий гаргагчийг хаана байрлуулах вэ?	Зуухны усны эргэлтийн хэсгийн хамгийн доод цэгт.	Зуухны усны эргэлтийн хэсгийн хамгийн дунд цэгт.	Зуухны усны эргэлтийн хэсгийн хамгийн дээд цэгт.	Сонголт байхгүй	Сонголт байхгүй
2	Зуухны дотоод үзлэгээр юуг шалгах вэ?	Галын хотлын өрлөг, дулаалга, экран хоолойн бүрэн бүтэн байдал, бохирдлыг шалгана.	Зөвхөн өрлөг дулаалгыг шалгана.	Хэмжих багаж хэрэгслийг ажиллагааг шалгана.	Сонголт байхгүй	Сонголт байхгүй
3	Шугам хоолойн болон хаалт, арматурын флансцан холболтуудыг яаж чангалах вэ?	Боолтуудыг нэг талаас нь дэс дарваалуулан чангална.	Голчийн дагуу эсрэг боолтуудыг эзлжлэн чангална.	Дурын боолтноос эхлэн чангална.	Сонголт байхгүй	Сонголт байхгүй
4	Зуухны халаах гадаргуугийн дотор талыг ямар аргуудаар цэвэрлэх вэ?	Механик ба гар ажиллагаатай хэрэгслүүдээр	Химийн аргаар	Дээрхи аргуудаар	Сонголт байхгүй	Сонголт байхгүй
5	Зуухны ямар температурт ажиллах хэсэгт шамотон тоосгон өрлөг хийх вэ?	700С-ээс дээш температуртай хэсгийн дотор талд	800С-ээс дээш температуртай хэсгийн дотор талд	900С-ээс дээш температуртай хэсгийн дотор талд	Сонголт байхгүй	Сонголт байхгүй
6	Тэлүүр (задвижка) хаалтыг ихэвчлэн ямар голчтой хоолойд угсрах вэ?	150мм-ээс дээш голчтой хоолойд ихэвчлэн тэлүүр хаалтыг хэрэглэнэ.	Дурын голчтой хоолойд ихэвчлэн тэлүүр хаалтыг хэрэглэнэ.	50мм-ээс дээш голчтой хоолойд ихэвчлэн тэлүүр хаалтыг хэрэглэнэ.	Сонголт байхгүй	Сонголт байхгүй
7	Буцаахгүй клапан ямар зорилгоор хэрэглэх вэ?	Насос осол аваарийн байдлаар зогсох тохиолдолд усны урсгалыг буцааж түүн рүү оруулахгүй байх зорилгоор төвөөс зугтаах насосны шахах тал дээр угсарна.	Насос осол аваарийн байдлаар зогсох тохиолдолд усны урсгалыг буцааж түүн рүү оруулахгүй байх зорилгоор төвөөс зугтаах насосны сорох тал дээр угсарна.	Насос осол аваарийн байдлаар зогсох тохиолдолд усны урсгалыг буцааж оруулахын тулд төвөөс зугтаах насосны шахах тал дээр угсарна.	Сонголт байхгүй	Сонголт байхгүй
8	Ашиглалтын явцад зуухны туслах тоноглолд ямар хяналт тавих вэ?	Үлэх салхилуурын ажиллагаанд тогтмол хяналт тавьж, илэрсэн гэмтэл, доголдлыг тухай бүрд нь арилгана.	Насоснуудын ажиллагаанд тогтмол хяналт тавьж, илэрсэн гэмтэл, доголдлыг тухай бүрд нь арилгана.	Дээрхи бүх үйлдлийг хийнэ.	Сонголт байхгүй	Сонголт байхгүй
9	Даралтат савыг ямар тохиолдолд аваарийн байдлаар яаралттай зогсоох вэ? А. Даралтат саван доторхи зөвшөөрөгдөх хэмжээнээс ихсэж зохих арга хэмжээ авсаар байтал буурахгүй бол Б. Хамгаалах хавхлага эвдэрсэн үед В. Зохиох будалт, бичилт арилсан.	А,Б,В	А,В	А,Б	Б,В	Сонголт байхгүй

10	Даралтат сав болон шугам хоолой ажиллуулдаг ажилчдын мэдлэгийн ээлжит шалгалтыг ямар хугацаанд авдаг вэ?	Жилд 1-ээс доошгүй удаа	12 сард 1-ээс доошгүй удаа	Сонголт байхгүй	Сонголт байхгүй	Сонголт байхгүй
11	Энэ дүрэмд хамаарагдахгүй даралтат савыг нэрлэнэ үү? А. Өөр бусад дүрмээр зохицуулах шаардлагатай цахраг идэвхт орчинд ажилладаг даралтат савууд, Б. Эрдэм шинжилгээний туршилтын зориулалт бүхий 0.025мЗ (25л) -ээс ихгүй багтаамжтай даралтаас хамаарахгүй даралтат савууд, В. Даралт (нэгж нь МПа буюу кгх /см2/), эзэлхүүн(мЗ, т-ээр)-ий үржвэр нь 0.02(200)-с ихгүй бөгөөд 0.025мЗ(25л) -с бага багтаамжтай даралтат сав болон баллонууд, Г. Технологи процесстой нь уялдан тэсрэлтийн улмаас дотор нь даралт үүсдэг савууд, Д. Шахсан шингэрүүлсэн хий, шингэн ба нунтаг бодисыг зөөх, хадгалах зориулалттай бөгөөд тэдгээрийг 0.07МПа(0.07кгх/см2)-с дээш даралт үүсгэж үе үе хоослоу суллах шаардлагатай цистерн, даралтат савууд	А,Б,В,Г,Д	А,Б,В	А,Б,В,Д	А,Б,В,Г	Д
12	Дараах шугам хоолой ямар ангилалд багтах вэ? Ажлын биеийн параметр: Температур- 560С-аас дээш, Даралт МПа кгс/см2- Хязгаарлагдахгүй	I	II	III	IV	Сонголт байхгүй
13	Арматурын хаягийн тэмдэг дээр юу бичих шаардлагатай вэ? А. Үйлдвэрлэсэн газрын нэр буюу бүтээгдхүүний тэмдэг, Б. Жишмэл голч мм, В. Жишмэл даралт МПа (кгх/см2), Г. Усны температур °С	А,Б	Б,В	В,Г	Б,В,Г	А,Б,В
14	"Уур халуун усны шугам хоолойг төхөөрөмжлөх, аюулгүй ашиглах дүрэм" -ийг дор дурдсан шугам хоолойд мөрдөхгүй.	III ангиллын 76мм-ээс бага гадаад голчтой шугам хоолой	III ангиллын 76мм гадаад голчтой шугам хоолой	III ангиллын 76мм-ээс бага дотоод голчтой шугам хоолой	III ангиллын 76мм дотоод голчтой шугам хоолой	Сонголт байхгүй
15	"Үйлдвэрлэлд гарсан ослыг судлан бүртгэх дүрэм" - ийг хэн батлах вэ?	Монгол улсны Засгийн газар	Улсын техник хяналтын байгууллага	Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн яам	Монгол улсын ажил олгогч эздийн нэгдсэн холбоо	Сонголт байхгүй
16	Манометрийг ямар хугацаанд баталгаажуулах вэ?	12 сард 1-ээс доошгүй удаа	Хагас жилд 1-ээс доошгүй удаа	Ашиглалтын зааварт тусгагдсан хугацаанд	Сонголт байхгүй	Сонголт байхгүй
17	Ямар шугам хоолойнуудыг ашиглалтанд оруулахын өмнө Улсын техник хяналтын байгууллагад бүртгүүлэх вэ? А. 100мм жишмэл голчтой III ангиллын шугам хоолойнууд, Б. 100мм-с их жишмэл голчтой III ангиллын шугам хоолойнууд, В. 100мм-с бага жишмэл голчтой III ангиллын шугам хоолойнууд,	А,Б	А,Б,В	Б,В	А,В	Б
18	Хиймэл амьсгал хийх арга-нэг хүнийх	Амнаас аманд	Хамраас хамарт	Бусдын тусламж заавал авах	Сонголт байхгүй	Сонголт байхгүй

19	Түвшний хэмжүүрийг яаж байрлуулдаг вэ? А. Үйлдвэрлэсэн газрын зааврын дагуу, Б. Налуу, В. Босоо	А	Б 3	А,Б	А,Б,В	Сонголт байхгүй
20	Хамгаалах хавчлагын үзүүлэлтийг тодорхойлох. А. Паспорт, Б. Ашиглалт, угсралт заавар, В. Зарцуулалтын коэффициент, гарах талбай	А	Б	А, Б	А,Б, В	Сонголт байхгүй
21	Даралтат сав, шугам хоолойн бүрэн бүтэн байдал аюулгүй ажиллагаа хариуцагчийгхэн томилох вэ? А. УМХЕГ, Б. Дүүргийн МХХ, В. Үйлдвэрийн захиргаа	А	Б	В	А,Б,В	Сонголт байхгүй
22	Баллоныг байрлуулах. А. Халаалтын хэрэгслээс 5м зайд, Б. Халаалтын хэрэгслээс 1м зайд, В. Коридорит, Г. Ил галаас 5м зайд	А	Б	А, Б	Б, В	Б, Г
23	Дараах шугам хоолой ямар ангилалд багтах вэ? Температур °С: 250 хүртэл, Даралт МПа(кг/см ²)- 1.6 (16) - 4.0(40)	I	II	III	IV	Сонголт байхгүй
24	Ам нээлхийн тагийг хэдэн килограммаас механикжуулдаг вэ? А.40кг, Б. 30кг, В. 20кг	А	Б	А,Б	В	Сонголт байхгүй
25	Хаалтыг сонгох үзүүлэлтүүдэд юу ордог вэ? А. Жишмэл даралт (Ру), Б. Жишмэл голч (Ду), В. Өнгө	А	Б	А,Б,В	Сонголт байхгүй	Сонголт байхгүй
26	Баллоны дүүргэлтийн хувь А.95%, Б.85%, В.100%	А	Б	А,Б	В	Сонголт байхгүй
27	Гэрэлтүүлэг хэдэн төрөлтэй вэ? А.2, Б. 3, В. 4	А	Б	А,Б,В	В	Сонголт байхгүй
28	Ямар голчтой савууд үзлэгийн нүхтэй байх вэ?	Ф 800мм ба түүнээс бага голчтой савууд	Ф 800мм ба түүнээс их голчтой савууд	Сонголт байхгүй	Сонголт байхгүй	Сонголт байхгүй
29	Энэ дүрмийг ямар хүрээнд мөрдөх ёстой вэ? А. 0.07 МПа-аас дээш даралттай уур буюу хийгээр ажилладаг даралтат савууд, Б. Шахсан шингэрүүлсэн хий, шингэн ба нунтаг бодисыг зөөх, хадгалах зориулалттай бөгөөд тэдгээрийг 0.07МПа-аас дээш даралт үүсгэж үе үе хоослож суллах шаардлагатай цистерн, даралтат савууд, В. Эмчилгээний барометрууд, Г. Уурын болон усан халаалтын хэрэгслүүд	А,Б,В,Г	А,Б,Г	Б,В,Г	А,Б,В	Сонголт байхгүй

30	Ашиглагч байгууллага манометрийг ямар хугацаанд шалгах ёстой вэ?	Даралтат сав ашиглагч нь 6 сард 1 удаа ажлын манометрийг шалгалтын манометрээр жишиж шалгаж, үр дүнг шалгалтын журналд тэмдэглэнэ.	Даралтат сав ашиглагч нь 12 сард 1 удаа ажлын манометрийг шалгалтын манометрээр жишиж шалгаж, үр дүнг шалгалтын журналд тэмдэглэнэ.	Сонголт байхгүй	Сонголт байхгүй	Сонголт байхгүй
31	Ямар шугам хоолойнуудыг ашиглалтанд оруулахын өмнө Улсын техник хяналтын байгууллагад бүртгүүлэх вэ? А. 100мм-с их жишмэл голчтой II ангиллын шугам хоолойнууд Б. 100мм-с бага жишмэл голчтой II ангиллын шугам хоолойнууд В. 100мм жишмэл голчтой II ангиллын шугам хоолойнууд	А,Б,В	А	А,Б	Б,В	Сонголт байхгүй
32	Насосонд кинетик энергийг ямар энерги болгох процесс явагддаг вэ?	Механик энерги	Дулааны энерги	Даралтын энерги	Потенциал энерги	Сонголт байхгүй
33	Сүлжээний усны насос №1,2-ын тип марк аль нь вэ?	KQSN600-M8/870F	KGSN600-M8/870G	KSSN600-M8/870S	Сонголт байхгүй	Сонголт байхгүй
34	Түүхий усны насосны тип марк аль нь вэ?	DFG125-250/7	DFG125-200/7	DFG125-280/7	Сонголт байхгүй	Сонголт байхгүй
35	Дотоод хэрэгцээний усны тип марк аль нь вэ?	JFS200-400 A/4	JFN200-400 A/4	JFG200-400 A/4	Сонголт байхгүй	Сонголт байхгүй
36	Дотоод хэрэгцээний нэмэлт усны насосны хүчин чадал хэд вэ?	5 м3/ц	6 м3/ц	5,5 м3/ц	6,5 м3/ц	Сонголт байхгүй
37	Сүлжээний усны насосны өргөх напор хэд вэ?	100 м	101 м	102 м	103 м	Сонголт байхгүй
38	Түүхий усны насосны хүчин чадал хэд вэ?	150 м3/ц	155 м3/ц	160 м3/ц	165 м3/ц	Сонголт байхгүй
39	Сүлжээний усны насос №1, 2-ын хүчин чадал хэд вэ?	3650 м3/ц	3700 м3/ц	3750 м3/ц	3800 м3/ц	Сонголт байхгүй
40	Түүхий усны насосны өргөх напор хэдэн метр байдаг вэ?	45м	50м	55м	60м	Сонголт байхгүй
41	Сүлжээний усны насос №3-ын хүчин чадал хэд вэ?	1800м3/ц	1850м3/ц	1900м3/ц	1950м3/ц	Сонголт байхгүй
42	Сүлжээний усны насосны моторын ороомгийн температурын хамгаалалт хэд дээр дохиолол өгөх вэ?	115°C	120°C	125°C	130°C	Сонголт байхгүй
43	Хөргөлтийн усны насосны тип марк аль нь вэ?	DFWH100-200	DFWH200-200	DFWH300-200	Сонголт байхгүй	Сонголт байхгүй
44	Хөргөлтийн усны насосны өргөх напор?	45м	50м	55м	60м	Сонголт байхгүй
45	Дотоод хэрэгцээний нэмэлт усны насосны үүрэг зориулалт юу вэ?	Дотоод хэрэгцээнд алдагдсан усыг нөхөх үүрэгтэй.	Дулааны шугам сүлжээнд нэмэлтээр ус өгөх үүрэгтэй.	Дээрх хариулт бүгд зөв	Сонголт байхгүй	Сонголт байхгүй
46	Сүлжээний усны насосны моторын холхивчны температурын хамгаалалт хэд дээр дохиолол өгөх вэ?	75°C	80°C	85°C	90°C	Сонголт байхгүй
47	Сүлжээний усны насосны буцах даралтын хамгаалалтын тавил хэд байдаг вэ?	0,1МПа	0,12МПа	0,125МПа	0,3МПа	Сонголт байхгүй
48	Сүлжээний усны насосны холхивчны температурын хамгаалалт хэд дээр дохиолол өгөх вэ?	80°C	85°C	90°C	95°C	Сонголт байхгүй
49	Сүлжээний усны насос №1, 2-ын доргiony хамгаалалт хэд дээр дохио өгч хэд дээр зогсох вэ?	3мм/с; 5 мм/с	3,5 мм/с; 4,5 мм/с	3 мм/с; 4,5 мм/с	3,5мм/с; 5 мм/с	Сонголт байхгүй
50	Сүлжээний усны насосны буцах даралт хэд дээр дохиолол өгөх вэ?	0,18МПа	0,16МПа	0,15МПа	0,125МПа	Сонголт байхгүй
51	Сүлжээний усны насос №3-ын доргiony хамгаалалт хэд дээр дохио өгч хэд дээр зогсох вэ?	3мм/с; 5 мм/с	3,5мм/с; 4,5 мм/с	3мм/с; 4,5 мм/с	3,5мм/с; 5 мм/с	Сонголт байхгүй

52	Даралт гэж юу вэ?	Стандартын даралтат савуудын бат бэхийн тооцоонд ашигладаг 20 хэм цельсийн температур дахь тооцоолсон даралт	5 Нэгж талбайд үйлчилж байгаа хүчний хэмжээ	Бат бэхийн тооцоо хийсэн даралт	Дээрх хариулт бүгд зөв	Сонголт байхгүй
53	Усан сорилтын үед даралтыг ямар хэмжээгээр алгуур нэмэх вэ?	2 ата/мин	1 ата/мин	0,5 ата/мин	Сонголт байхгүй	Сонголт байхгүй
54	2,5-14 МПа (25-140кг/см ²) байхад манометрийн заалтын нарийвчлалын ангилал нь хэд байх вэ?	1	1,5	2	2,5	Сонголт байхгүй
55	Насос, компрессорын шахах талд ямар төрлийн хаах арматур байдаг вэ?	Хаах	Таслах	Юүлэх	Тохируулах	Үл буцаах
56	12мм-ийн зузаантай тогоотой зуухны экраны ханын зузаан 5мм бол усан сорилтыг ямар хугацаанд хийх вэ?	20 мин	15 мин	10 мин	Сонголт байхгүй	Сонголт байхгүй
57	2,5МПа (25 кг/см ²) хүртэл байхад манометрийн заалтын нарийвчлалын ангилал нь хэд байх вэ?	1	1,5	2	2,5	Сонголт байхгүй
58	Сийрэгжилтийг ямар хэмжих хэрэгслээр хэмжих вэ?	Барометр	Манометр	Вакуумметр	Сонголт байхгүй	Сонголт байхгүй
59	Зэврэлтэнд тэсвэртэй ган хийхийн тулд химийн ямар нэмэлт хийсэн байдаг вэ?	Устөрөгч, агаар	Нүүрстөрөгч, хүчилтөрөгч	Хром, никель, мангани, вольфром, цахиур, фосфор	Сонголт байхгүй	Сонголт байхгүй
60	Хамгаалах төхөөрөмжийн үүрэг юу вэ?	Уур усны даралт байж болох хэвийн хэмжээнээс ихэссэн тохиолдолд ажиглаж илүүдэл даралтыг гадагш гаргах	Ажлын биеийн урсгалыг зөвхөн нэг чигт дамжуулах	Уур, усны даралт, зарцуулалтыг тогтоосон хэмжээнд тохируулах	Сонголт байхгүй	Сонголт байхгүй
61	10ХМФ маркийн гангийн температурын дээд хязгаарыг дугуйлна уу?	650°C	600°C	580°C	Сонголт байхгүй	Сонголт байхгүй
62	Галын хотол дахь шаталтын процесс сийрэгжилтэнд явагдах шалтгаан юу вэ?	Галын хотлын шаталтыг тогтвортой явуулах	Галын хотлын шаталтыг бууруулах	Сонголт байхгүй	Сонголт байхгүй	Сонголт байхгүй
63	Нээлхийний хэмжээ хэд байх нь оновчтой вэ?	Дугуй хэлбэртэй ам нээлхийний дотоод голч 450-500мм-ээс багагүй	Зууван хэлбэртэй ам нээлхийний хамгийн бага хамгийн их тэнцлэгийн хэмжээ нь 325-450мм-ээс багагүй	Дээрх хариулт бүгд зөв	Сонголт байхгүй	Сонголт байхгүй
64	Эр, эм /гайка/ боолт, сүлбээрийг ижил маркийн гангаар хийж болох уу?	Болно. Тасрах магадлал бага байна.	Болохгүй. Заавал өөр төрлийн гангаар хийнэ.	Сонголт байхгүй	Сонголт байхгүй	Сонголт байхгүй
65	Даралтанд ажилладаг эдлэхүүнд гагнуурын ажил хийхээр тухайн байгууллагад /угсралтын буюу засварын хэсэг/ анх орж буй гагнуурчин нь үнэмлэх гэрчилгээтэй эсэхээс үл хамааран ажилд орохын өмнө шалгалтын гагнаас хийж, шалгуулах шаардлагагүй.	Үнэн	Худал	Сонголт байхгүй	Сонголт байхгүй	Сонголт байхгүй
66	Гагнуурчин болон гагнуур хийгдэх ажлын байр ньбайна. Цэгийн оронд тохирох хариултыг дугуйлна уу.	Агаарын хур тундастай	Салхитай	Нартай	Дээрхи бүгд	Сонголт байхгүй
67	Гагнуурын шалгалтын хэдэн арга байх вэ?	Үл эвдэх	Эвдэх сорил	Дээрх хоёулаа	Сонголт байхгүй	Сонголт байхгүй

68	Дотоод журамд зааснаар "...эрүүл мэндийн байдал хэвийн биш ажигтанд..." ээлж хүлээлгэн өгч болох уу?	Ээлж хүлээлгэж болно.	Ээлж бүлээлгэхийг хориглоно.	Удирдлагаас өгсөн шийдвэрийг үндэслэн ээлж хүлээлгэх эсэхийг шийдвэрлэнэ.	Сонголт байхгүй	Сонголт байхгүй
69	Ажил олгогч нь ажилтнаас ажил үүргээ биелүүлэхийг шаардаж болох уу?	Хууль зөрчсөн албадлагын шинж чанартай үйлдэл тул хуулиар хориглосон	Ажилтан гэрээ байгуулсан учир сайн дураар ажиллах эрхтэй.	Болохгүй	Болно	Сонголт байхгүй
70	Хөдөлмөрийн дотоод журамд зааснаар Ажлаас халах үндэслэл аль нь вэ?	Компанийн эд хөрөнгийг дур мэдэн авсан, 400,000 төгрөгнөөс дээш хохирол учруулсан.	Үгсэн хуйвалдсан, 400,000 төгрөгнөөс доош хохирол учруулсан	Бүгд зөв	Сонголт байхгүй	Сонголт байхгүй
71	Дотоод журамд зааснаар "Ажилтнуудын ажлын онцлогт тохирсон, аюулгүй ажиллагааны шаардлагад нийцсэн чанартай хувцас, хамгаалах хэрэгслээр хангах" нь хэний үүрэг вэ?	Ажил олгогчийн үүрэг	Ажилтны үүрэг	Бүгд зөв	Сонголт байхгүй	Сонголт байхгүй
72	Ажилтан санал хүсэлт, гомдлоо захиргаанд ямар хэлбэрээр тавьж шийдвэрлүүлэх вэ?	Аман болон бичгээр	Заавал бичгээр	Сонголт байхгүй	Сонголт байхгүй	Сонголт байхгүй
73	Ээлжинд ажиллагсад нь ажил эхлэхээс хэдэн минутын өмнө ажлын байранд ирэх вэ?	1 цаг	15 минут	30 минут	Заалт байхгүй	Сонголт байхгүй
74	Ээлжийн ажиллагсад хүндэтгэн үзэх шалтгааны улмаас ажилдаа гарах боломжгүй болсон тохиолдолд хэсгийн удирдлагагад ямар хугацаанд мэдэгдэх вэ?	8 цагийн өмнө	Ажил хүлээлгэн өгөхөөс өмнө	4 цагийн өмнө	1 цагийн өмнө	Сонголт байхгүй
75	Үндсэн цалин буюу албан тушаалын цалингийн хэмжээг юунд тусгах вэ?	Хөдөлмөрийн гэрээ	Дотоод журамд	Хөдөлмөрийн Хууль	Хамтын гэрээ	Сонголт байхгүй
76	Хөдөлмөрийн дотоод журманд зааснаар сахилгын шийтгэл ногдуулсанаас хойш ямар хугацаа өнгөрвөл уг ажилтныг сахилгын шийтгэлгүйд тооцох вэ?	3 сар	6 сар	1 жил	1 сар	Сонголт байхгүй
77	Сахилгын зөрчлийн улмаас бага хэмжээний /Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээгээс доош/ хохирол учруулсан болон анх удаа зөрчил гаргасан ажилтанд ямар сахилгын шийтгэл ногдуулах вэ?	Ажлаас халах	Цалин хөлсийг 3 сар хүртэл хугацаагаар 20 хүртэл хувиар бууруулах	Сануулах	Сонголт байхгүй	Сонголт байхгүй
78	Ажил олгогч нь ажилтнаас ажил үүргээ биелүүлэхийг шаардаж болох уу?	Хууль зөрчсөн албадлагын шинж чанартай үйлдэл тул хуулиар хориглосон	Ажилтан гэрээ байгуулсан учир сайн дураар ажиллах эрхтэй.	Болохгүй	Болно	Сонголт байхгүй
79	Хөдөлмөрийн дотоод журамд зааснаар Ажлаас халах үндэслэл аль нь вэ?	Компанийн эд хөрөнгийг дур мэдэн авсан, 400,000 төгрөгнөөс дээш хохирол учруулсан	Үгсэн хуйвалдсан, 400,000 төгрөгнөөс доош хохирол учруулсан	бүгд зөв	Сонголт байхгүй	Сонголт байхгүй
80	Эд хөрөнгийн бүрэн хариуцлагын гэрээг ямар ажилтантай байгуулах вэ?	Бүх ажилтантай	Зөвхөн эд хөрөнгө хариуцах ажилтантай	Тухайн цех хэсгийн бүх ажилтантай	Сонголт байхгүй	Сонголт байхгүй
81	Ээлж хүлээн авахад илэрсэн зөрчил, дутаалдтай зүйлүүдийн тухай хэнд мэдэгдэх вэ?	Удирдлагад	Станцын ээлжийн инженер, удирдлагад	Станцын ээлжийн инженер, удирдлагад	Сонголт байхгүй	Сонголт байхгүй

82	Ээлжийн ажилтан дараагийн ээлжийн ажилтан ирээгүй тохиолдолд ямар арга хэмжээ авах вэ?	Хариуцсан удирдлагадаа мэдэгдэн тухайн ээлжийн аль нэг ажилтанд ажлыг хүлээлгэн өгнө.	7 Дараагийн ээлжийн ажилтан иртэл ажил үүргээ үргэлжлүүлнэ.	Дээрх хариулт бүгд буруу.	Сонголт байхгүй	Сонголт байхгүй
83	Аваарийн нөхцөл байдалтай үед ээлж хүлээлцэж болох уу?	Техникийн удирдлага зөвшөөрсөн тохиолдолд болно.	Техникийн комиссийн шийдвэр гарсан тохиолдолд болно.	Дээрх хариултууд буруу.	Сонголт байхгүй	Сонголт байхгүй
84	Ээлжийн ажилтан ажилдаа ирэх боломжгүй тохиолдолд хэнд мэдэгдэх вэ?	Хэсгийн удирдлагад 4 цагийн өмнө мэдэгдэнэ.	Станцын ээлжийн инженерт 4 цагийн өмнө мэдэгдэнэ.	Захиргаанд 4 цагийн өмнө мэдэгдэнэ.	Сонголт байхгүй	Сонголт байхгүй
85	Аваарийн нөхцөл байдалд ээлж хүлээн авах ажилтан аваари устгах ажиллагаанд оролцох уу?	Аваарийн байдлыг удирдаж байгаа хүний шийдвэрээр зөвшөөрнө.	Ээлж хүлээн авсан тохиолдолд зөвшөөрнө.	Аваарийг устгасан тохиолдолд зөвшөөрнө.	Сонголт байхгүй	Сонголт байхгүй